



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 06 сарын 31 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, 22 дугаар зүйлийн 22.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 5.2 дугаар зүйлийн 8, 5.3 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.11, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэйн стрит финанс ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Мэйн стрит финанс ББСБ” (Б.Цэвээн-Очир)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН